



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗҮЙН АСУУДАЛ

№11 (27)

Улаанбаатар 2015

Түймрийн эрсдэлийг үнэлэх аргазүйн асуудалд (Н.Болдбаатар)	118
Ханбогд сумын экологийн эмзэг байдлын үнэлгээ (Д.Батнямбуу)	125
Хараа голын урсацад үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг загварчлалын аргазүй ашиглан тооцох (Ё.Амарбаясгалан, З.Мөнхцэцэг, Я.Жамбалжав)	133
Ландшафтын орон зайн загварыг ГМС-д суурилсан олон шалгуурт шийдвэр гаргалтын аргатай хослуулж ландшафтын зураглалд ашиглах асуудалд (Монгол орны зүүн бүсийн жишээн дээр) (О.Мөнхдуулам)	143
Тээврийн хэрэгслийн дугуйн эргэлтээс үүсэх тоосонцорын хэмжилт, судалгаа (Б.Батдэлгэр, Ч.Бямбацэрэн)	150
Хэнтий аймгийн ландшафтын гадны нөлөөнд өртөх эрсдэлийг үнэлэх нь (Т.Рэнчинмядаг, Ц.Батням, Т.Даваагатан)	158
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ГАЗАРЗҮЙН АСУУДАЛ	
Монгол орны зүүн бүсийн ландшафтын ашиглалт, хамгаалалтын асуудал (Б.Оюунгэрэл, Т.Рэнчинмядаг)	165
Гол мөрний усан зам, тээврийн газарзүйн чухал салбар мөн (Д.Энхбаяр, Г.Урантамир)	174
Монгол улсад нутгийнханы бэлчээрийн менежментийн институцийн амжилтад нөлөөлөх чухал хүчин зүйлсийн тухайд (У.Тунгалаг, Мария Фернандес-Хименес)	182
Тавдугаар дулааны цахилгаан станцын төлөвлөлтийн талбайн мөнхцэвдэгийн тархалтын судалгааны үр дүн (Г.Цогт-Эрдэнэ, Я.Жамбалжав, Х.Тэмүүжин)	191
Боловсролын үйлчилгээний салбарын нөлөөгөөр хүн амын нутагшилтанд гарч буй өөрчлөлтүүд (Ц.Отгонхүү)	197
“Монголын нууц товчоо”-н дахь газарзүйн дэвсгэр нэр (Д.Энхбаяр, Б.Авирмэд, Д.Даш)	205
Монголд нутгийнханы бэлчээрийн менежментээс гарч буй нийгмийн зерэг үр дүнг хэрхэн тайлбарлах вэ? (У.Тунгалаг, Мария Фернандес-Хименес)	211
Capital cities relocation: implication for Mongolia (G.Gantulga, B.Bilguun) ...	219
Говийн бүсийн аймгуудын хүн амын нутагшил, суурьшил (Б.Батбуян, Д.Хишигдорж)	226
Mongolia and tourism in North Asia (M.Biligsaikhan)	236
Development of multistructured agriculture in the republic of Buryatia (O.A. Yekimovskaya)	243
Геоэкологическая характеристика и оценка территории проектируемого государственного природного резервата «Бокейорда» Западно-Казахстанской области (Т.К.Салихов, Е.Ж.Гармаев, Ж.М.Карагойшин, Т.С.Салихова)	250
ЭРДЭМТНИЙ БУЛАН	258
Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор Дамбын Базаргүр (Д.Энхбаяр)	258

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ГАЗАРЗҮЙН АСУУДАЛ

МОНГОЛ ОРНЫ ЗҮҮН БҮСИЙН ЛАНДШАФТЫН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН АСУУДАЛД

Б.Оюунгэрэл¹, Т.Рэнчинмядаг¹

¹ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Физик газарзүйн салбар,
Эшуудан: oyun_bad@yahoo.com_myadag_2004@yahoo.com

Abstract

Eastern Mongolia dominated by arid steppe and arid desert steppe landscape. Far eastern end is Khyangan mountain where forest and forest steppes are prevailed. 70% of total land is moderately and intermediary degraded and 30% is severely degraded. Therefore, Eastern Mongolia's landscape require conservation attention and resources need to be sustainably used.

Түлхүүр үгс: Зүүн бүс, ландшафтын ашиглалт, хамгаалалт, тусгай хамгаалалттай газар, аялал жуулчлал

Хураангуй

Монгол орны зүүн бүсэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд хамрагдах бөгөөд манай орны нийт нутгийн 20 орчим хувийг эзэлдэг. Монгол орны дорнод хэсгийн гурван аймгийн нутаг бол хойноос Сибирийн хөвч тайга, баруун өмнөөс Төв Азийн заримдаг цөл, зүүнээс Дагуурын хээр, Их Хянганы уулс түрэн орж ирсэн ихээхэн өвөрмөц байрлалд оршиж олон хэвшинжийн ялгаатай ландшафтыг бүрдүүлнэ. Монгол орны зүүн бүсэд хээр, хуурай хээрийн ландшафт, өмнөд хэсгээр цөлжүү хээрийн ландшафт зонхилон тархдаг байна. Нутгийн хамгийн зүүн захаар Хянганы уулархаг мужид ой, ойт хээрийн ландшафт зонхилно. Монгол орны зүүн бүс нутгийн ландшафт 92% нь хөдөө аж ахуйд, 6% орчим нь ойтой. Нийт бэлчээрийн эдэлбэр газрын 70 орчим хувь нь сул ба дунд зэрэг, 30 орчим нь хүчтэй ба нэн хүчтэй талхлагдаж ашиг шим нь нэлэнхийдээ буурсан байна. Иймээс зүүн бүсийн ландшафтыг хамгаалах, зохистой ашиглах асуудал чухлаар тавигдаж байна.

Монгол орны зүүн бүсийн байгалийн нөхцөл. Монгол орны зүүн хэсэг манай орны нийт нутгийн 20 орчим хувийг эзэлдэг. Засаг захиргааны хуваариар Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд хамрагдана.

Зүүн бүсийн газарзүйн байрлалыг математик координатын үзүүлэлтээр тодорхойлбол баруунаас зүүн тийш зүүн уртрагийн $107^{\circ}45'$ -aac $119^{\circ}57'$ хүртэл, хойноос урагшаа хойт өргөргийн $50^{\circ}20'$ -aac $45^{\circ}20'$ хүртэлх зайцад оршино (Доржготов, 2007).

Тус нутаг баруун талаараа Хэнтийн нуруу, өмнө талаараа Хэрлэнгийн урд биеийн бэсрэг уулс, Дарьгангын хүрмэн чuluун тэгш өндөрлөг (базальтовое плато), зүүн талаараа Их Хянганы уулсаар хүрээлэгдэн орших бөгөөд үнэмлэхүй өндөршлийн хувьд хамгийн өндөр цэг нь Их Хэнтийн нурууны Даваатын сарьдаг (2413 м), хамгийн нам цэг нь Улз голын адаг хавьцаа орших Хөх нуурын хонхор (560 м) юм. Газрын гадаргын нөхцөл байдлын хувьд Хэнтийн нуруу, Их Хянганы уулсын хоорондох томоохон тектоник хотгорыг бүхэлд нь эзэлсэн талархаг газар зонхилен. Геологийн тогтцын хувьд Онон-Улз голын сав нутагт далайн тунамал чuluулаг, Хэнтийн нурууны салбар уулсаар перм, триас, юрийн заримдаа бүр эртний кембрийн галавт үүссэн боржинлог (гранитоид) бүрдлийн гүний талст чuluулаг, ухаа гувээ, цав толгод, өндөрлөг тал газраар янз бүрийн эрин галавт үүссэн галт уулын бялхмал чuluулаг тархжээ. Эх газрын тунамал хурдсын дотор нүүрс агуулагч үеүд цөөнгүй тохиолдоно. Зарим газар (Матад орчимд) нефтийн хуримтлал илэрсэн байна.

Тус нутагт хуурай хээрийн хүрэн шороон хөрс хамгийн их тархаж тус нутгийн нийт талбайн 64 орчим хувийг эзэлнэ. Уулын ой, тайгын хөрсний нийлбэр талбай нийт нутгийн 12 хувиас хэтрэхгүй. Онон, Улз, Халх голын савд хар шороон хөрс нэлээд тархаж нийт нутгийн 14 орчим хувьтай тэнцэх талбайг хамарна. Эдгээрээс гадна нуга, намгийн хөрс, голын татмын (аллювийн) хөрс, хужир, мараа зэрэг бүс дундын хөрс тус тус багахан хэмжээгээр тархжээ.

Зүүн бүс нутагт Онон, Улз, Хэрлэн, Халх гол болон тэдгээрт цутгадаг 400 гаруй гол, горхи багтана. Эдгээрээс байнгын ургалтай голуудын нийт урт 2000 орчим км бөгөөд тэндхийн голуудын зарим (Онон) нь Амар мөрөнд шууд цутгадаг бол зарим (Хэрлэн, Халх гол) нь Буйр, Далай нуураар дамжин Амар мөрөнд усаа нийлүүлдэг байна. Ийнхүү Монголын зүүн хэсгийн голууд зөвхөн Амар мөрнөөр дамжуулан Номхон далайд усаа юулдэг тул тус нутгийг Монгол дахь Амар мөрний сав нутаг гэж үзэж болно. Амар мөрний сав газрын Монгол дахь хэсгийн ус хураах талбайн нийт хэмжээ 235000 орчим км² бөгөөд энэ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 15 хувьтай тэнцүү юм. Зүүн бүсийн хамгийн том нуур болох Буйр нуур Хятадтай хил залгаа нутагт орших бөгөөд Халх голын усаар тэжээгдэнэ. Хятадын нутагт Буйр нуураас Оршуун гол эх авч Далай нуур луу урсдаг тул Буйр нуурын зүүн хойт хэсгийн ус илүү цэнгэг байна. Буйр нуур нь фитопланктон, планктон, бентос амьтны төрөл зүйлээр арвин, биомассын агууламж ихтэй, манай орны хамгийн үржил шимтэй нуурт тооцогдох бөгөөд тэнд 29 зүйлийн загас амьдардаг. Тус нутагт Буйр нуураас гадна 370 гаруй жижиг нуур бий.

Үүр амьсгалын хувьд сэргүүтгэр эх газарлаг уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж температур +0.5°C-аас -3°C, нэгдүгээр сарын агаарын дундаж температур -20°C - -24°C, долдугаар сарынх +16°C - +22°C байна. Хамгийн их хүйтэн нь -40.1°C - -46.7°C, хамгийн их халуун нь +38.9°C - +40.1°C хүрдэг. Олон жилийн цэвдэг зөвхөн Хэнтийн нурууны өндөрлөг хэсгээр бага зэрэг тархана. Улирлын цэвдэг нэлэнхийдээ тархах ба хөрсний хөлдөлтийн гүн 2.5-3.5м хүрнэ.

Зүүн бүс нутгийн хүрээнд амьтан ургамлын амьдрах орчны төлөв байдлаар хоорондоо ялгаатай ландшафтын 3 бүс нутаг (экорегион) тодорхой ялгарч харагдана. Үүнд: 1) Хэнтийн гол нурууны зүүн хэсгийг хамарсан уулын тайгын ландшафт бүхий дундаж (далайн түвшнээс дээш 1500-2300 м) өндөр уулс. Энд Байгал нуур орчмын шилмүүст ойн хамгийн өмнөд үргэлжлэл болох хуш, сибирь шинэсэн ой голлон ургажээ. 2) Эндээс зүүн тийш Онон, Балж голын савд Сибирь шинэс, Дагуур шинэс, нарс, хусан ой бүхий ойт-хээрийн ландшафт зонхилсон нам уулархаг (далайн

түвшнээс дээш 1000-1500 м өндөр) нутаг орших бөгөөд энэхүү Дагуурын ойт хээр нь зүүн хойшоо Онон голын савыг дагаж Оросын нутаг руу нэлээд үргэлжилнэ. 3) Эндээс өмнө, зүүн өмнө, зүүн зүг рүү Монголын Дорнодын тал нутгийг бүхэлд нь бүрхсэн хуурай хээрийн ландшафт үргэлжилнэ.

Зүүн бүсийн байгаль орчны төлөв байдал. Монгол орны зүүн бүсийн сав нутгийн хэмжээнд байгаль ашиглалтын байдлыг авч үзвэл нийт нутаг дэвсгэрийн 92% нь хөдөө аж ахуйн газар, 6% орчим нь ойн сангийн газарт хамрагдана. Нийт бэлчээрийн эдэлбэр газрын 70 орчим хувь нь сул ба дунд зэрэг, 30 орчим нь хүчтэй ба нэн хүчтэй талхлагдаж ашиг шим нь нэлэнхийдээ буурсан байна.

Ойн нийт талбай 1400 мян. га орчим бөгөөд сүүлийн жилүүдэд ойн экосистемийн тэнцвэрт байдал ихээхэн алдагдаж ойн нөөц жилээс жилд хомсодсоор байгаагийн гол шалтгаан нь ойн түймэр, эмх замбараагүй мод огтлолт, хортон шавжийн учруулж буй хөнөөл юм.

Усны нийт нөөц хэмжээ 8300 сая м³ орчим бөгөөд түүний хуваарилалт маш жигд биш. Нутгийн хойт хэсгээр усны хангамж хүрэлцээтэй байдаг бол өмнөд хэсгээр Сүхбаатар, Дорнод аймгийн урд талаар гадаргын ба гүний усны нөөц маш багатай. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалыг ил аргаар олборлох, хайгуул шинжилгээ хийх, ялангуяа алт олборлох үйл ажиллагаа хэт өргөжсөний уршигаар голуудын сав хөндий, голдрилын дагуух газрууд маш ихээр эвдэгдэж, тэндхийн хөрс широо, байгалийн экосистем бүрмөсөн устаж үгүй болох аюул нүүрлэж буй нь экологийн хямралд хүргэж болзошгүй байна.

Тус бус нутагт ховор ба нэн ховор амьтан ургамал цөөнгүй бий. Монгол Улсын улаан номд бүртгэгдсэн 10 зүйл хөхтөн, 15 зүйл шувуу, 2 зүйл хоёр нутагттан, 1 зүйл мөлхөгч амьтан, 4 зүйл загас, 6 зүйл шавж, 2 зүйл хавч хэлбэртэн, 3 зүйл зөөлөн биетэн эндхийн гол нуур, уул толгод, хээр талд амьдардгаас гадна 51 зүйл дээд ургамал, 2 зүйл замаг, 5 зүйл хаг, 6 зүйл мөөг энэ нутагт тархан ургадаг.

Зүүн бүсийн ТХГН (тусгай хамгаалалттай газар нутаг)-ийн сүлжээ. Нийт нутгийн 10 гаруй хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг явдал байгалийн экосистемийн унаган төрх байдлыг хадгалан хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг (1 дүгээр зураг). Биологийн төрөл зүйл, байгалийн унаган төрх, экосистемийн өвөрмөц иж бүрдлийг хадгалан хамгаалах зорилгоор Монгол орны зүүн бус нутгийн хэмжээнд Дархан цаазат газар 4 (Хан Хэntий, Монгол Дагуур, Нөмрөг, Дөрнод Монголын), байгалийн цогцолборт газар 3 (Онон-Балж, Өндөрхаан уул, Дарьганга), байгалийн нөөц газар 9 (Угтам, Яхь нуур, Тосон-Хулстай, Хар Ямаат, Лхачинвандад, Онгон таван булаг, Баянцагааны тал, Дархан уул, Хэрлэн тооно уул), байгалийн дурсгалт газар 5 (Шилийн бодг, Хөрөгийн хөндий, Дарханхаан уул, Биндэръяа хан уул, Хангал нуур) нийт 21 тусгай хамгаалалттай газрыг хуульчлан байгуулж бүгд 5028.3 мянган га талбайг улсын хамгаалалтад авсан нь Монгол Улсын төр засгаас байгаль хамгаалах талаар хэрэгжүүлж буй бодлогын шинжтэй томоохон бодит үйл ажиллагаа юм.

Монгол орны геоструктурын онцлог, морфоструктурын шинжид тулгуурлан ландшафтын гарал үүслийн зарчмыг баримтлан тогтоосон байгалийн мужлал, уур амьсгалын орон нутгийн онцлог, морфоструктурын байдлаас хамааран өргөргийн байршил, өндрийн түвшнийг дагаж илрэх байгалийн бус, бүслүүрийн ялгаа нь газар нутгийг хамгаалалтад авах үндсэн шалгуур болсон юм.



1 дүгээр зураг. Зүүн бүсийн ТХГН

Монгол орны дорнод хэсэгт Хэнтийн уулт тайгын муж, Дагуурын уулын хээрийн муж, Дорнод Монголын хээрийн муж, Дарьганга-Эрдэнэцагааны уулын хээрийн муж, Хянганы баруун хэсгийн ойт хээрийн муж гэсэн байгалийн бие даасан 5 муж ялгарах бөгөөд дотор нь дэд мужууд ялгарч байна (1 дүгээр хүснэгт).

1 дүгээр хүснэгт. Зүүн бүсийн ТХГН-ийн байгалийн мужийн төлөөлөл

Байгалийн муж, дэд муж	Мужийн талбай	Тусгай хамгаалалттай газрууд	ТХГН-ийн талбай	Мужид эзлэх %
<i>Хэнтийн уулт тайгын муж</i>				
Хэнтийн нурууны төв хэсгийн дэд муж	2935505	Хан Хэнтийн ДЦГ	15381.1	52.4
Хэнтийн нурууны зүүн хэсгийн дэд муж	2009897	Онон-Балжийн БЦГ Биндэръяа хан уул Хангаль нуур	4538.8	20.6
<i>Дагуурын уулын хээрийн муж</i>				
Улз голын сав газрын дэд муж	3280835	Угтам уул БНГ Монгол Дагуур ДЦГ “А” хэсэг	1237.1	3.7
<i>Дорнод Монголын хээрийн муж</i>				
Хэрлэн голын хойд биеийн дэд муж	4401276	Монгол Дагуур ДЦГ “Б” хэсэг Яхь нуур БНГ Тосон Хулстай БНГ Хар Ямаат БНГ	7294.9	16.6
Өндөрхаан-Баруун уртын дэд муж	9143027	Өндөрхаан уулын БЦГ Баянцагааны тал Дархан уул Хэрлэн тооно Дарханхаан уул	354497	3,8
Мэнэнгийн талын дэд муж	4079078	Дорнодын тал хээрийн ДЦГ	771.8	1.89

Дарьганга-Эрдэнэцагааны уулын хээрийн муж

Дарьганга тэгш өндөрлөгийн дэд муж	1352430	Дарьгангын БЦГ Шилийн богд	62860 23200	6.4
Эрдэнэцагааны нам улсын дэд муж	1362414	Дорнод Монголын ДЦГ Лхачинвандад БНГ	4889.1	35.9

Хянганы баруун хэсгийн ойт хээрийн муж

Дэгээ-Нэмрөг голын савын дэд муж	844286	Нэмрөг ДЦГ Дорнод Монголын ДЦГ	3632.6	43.3
-------------------------------------	--------	-----------------------------------	--------	------

Хүснэгтээс харвал зүүн бүсийн ТХГН-ийн сүлжээнд Хянганы баруун хэсгийн ойт хээрийн муж, Эрдэнэцагааны нам улсын дэд муж, Хэнтийн нурууны төв, зүүн хэсгийн дэд мужийн төлөөлөл харьцангуй хангалттай бол Хэнтийн нурууны өвөр хэсэг, Дарьгангын тэгш өндөрлөг, Өндөрхаан-Баруун-Уртын дэд мужуудын төлөөлөл хангалтгүй байна. Дундад халхын тэгш өндөрлөгийн дэд мужид огт төлөөлөлгүй байна.

Манай орны нутаг дэвсгэр өргөн уудам, хойноосоо урагшаа 1200 гаруй км үргэлжлэх тул тэр чиглэлд ландшафтын төрх, байгалийн нөхцөл хувьсан өөрчлөгджөк байгалийн хэд хэдэн бүс, бүслүүр дараалан орших агаад тухайлбал өндөр уулын бүслүүр, уулт тайгын бүслүүр, ойт хээрийн бүс, хээрийн бүс, заримдаг цөлийн бүс, цөлийн бүс ээлжлэн оршино. Зүүн бүсийн ТХГН-ийн байгалийн бүс бүслүүрийн төлөөллийг авч үзэв (2 дугаар хүснэгт).

**2 дугаар хүснэгт. Тусгай хамгаалалттай газруудын
байгалийн бүс, бүслүүрийн төлөөлөл**

д/д	Байгалийн бүс, бүслүүрийн нэр	Тухайн бүс, бүслүүрт хамрагдах ТХГН	ТХГ-ын талбай (мян.га)	Бүс, бүслүү- рийн эзлэх талбай (км ²)	Тухайн бүсийн ТХГ-ын эзлэх хувь
2	Ойт хээр	Нэмрөг	311205		
		Угтам уул	46160	238108.0	5.2
		Онон-Балж	415752		
		Биндэръяа хан уул	103016		
		Монгол Дагуур	570374		
		Дорнод Монгол	58800		
		Лхачинвандад	62860		
3	Хээр	Дарьганга	23200		
		Шилийн богд	469928	535743.0	4.2
		Тосон Хулстай	251388		
		Яхь	50594		
		Хар Ямаат	332400		
		Баянцагааны тал	4854		
		Дархан уул	4461		
		Хэрлэн тооно уул			

Ойт хээрийн бүсэд байгаа газрууд тооны хувьд олон боловч талбайн хэмжээгээр бага учраас бүсийн маш бага хувийг эзэлж байна. Хээрийн бүсэд Дорнод Монгол, Монгол Дагуурын дархан цаазат газар, Хустай нуруу, Дарьгангын байгалийн

цогцолборт газар, Тосон Хулстай, Яхь нуур, Хар Ямаат, Угтам уул, Шилийн богд, Хөрөгийн хөндийн дурсгалт газар орох бөгөөд хамгийн их төлөөлөлтэй юм. Гэхдээ эдгээр газруудын нийлбэр талбай нийт хээрийн бүсийн дөнгөж 4.2 хувийт эзэлнэ. Энэ нь байгалийн бүс бүслүүрийн төлөөллийн хувьд маш хангалтгүй учраас тодорхой газруудыг хамгаалалтад авч сүлжээг өргөтгөх шаардлага гарч байна.


Зүүн бүсийн ландшафтын хамгаалалтын асуудлууд. Цаашид зүүн бүс нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад хамгаалалтын оновчтой менежментийг хэрэгжүүлэх, түүний дотор дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх боломжтой юм. Үүнд:

1. TXGN-ийн хамгаалалтын менежментийг сайжруулах. Юуны өмнө одоогийн TXGN-ийн хамгаалалтын байдалд үнэлгээ хийж үзэх, улмаар бодит судалгаанд үндэслэн хамгаалалтын оновчтой менежментийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал Монгол Дагуурын дархан цаазат газар хамгаалалттай газар нутгийн шинэ ангилал, хуулиар хамгаалалтад авснаас хойш 20 жил болсон байна. Энэ хугацаанд хэрхэн хамгаалагдсан, хамгаалалтад авснаар ямар өөрчлөлт гарсан, өөрчлөлтөд оруулахад хүргэж буй хүчин зүйлүүдийг нягтлан судалж тогтоох, байгаль орчны өөрчлөлтийг нийгэм эдийн засгийн байдалтай нь уялдуулан судалж үнэлэлт өгөх, судалгааны үр дунд тулгуурлан өөрчлөлтийн шалтгааныг тодруулан цаашид хэрэгжүүлэх оновчтой менежментийг тодорхойлон хэрэгжүүлэх хэрэгтэй юм.
2. Тусгай хамгаалалттай газар нутгийг сонгох шалгуурыг ахин нягтлан үзэж сүлжээг өргөжүүлэх. TNC (The Nature Conservancy) Олон улсын байгууллагаас Монгол орны зүүн бүсийн экологийн иж бүрэн үнэлгээг хийж хамгаалах шаардлагатай экологийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг сонгосон байна. Энэхүү үнэлгээгээр Монгол орны зүүн бүсэд 60 газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатайг тогтоосон байна. Зүүн бүсийн ландшафтад ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз бүхий газрууд томоохон аюул учруулах магадлалтай байна.
Зүүн бүс нутгийн TXGN-ийн сүлжээний байдалд үнэлгээ хийж үзвэл байгалийн муж, бүс бүслүүрийн төлөөллийн хувьд хангалтгүй, цаашид төлөөллийн хувьд ч, төрөл зүйлийн хувьд ч өргөтгөх шаардлагатай газрууд олон байна.
Байршил нутгийн хувьд бага хэмжээтэй хамгаалагдаж буй ховор, ховордсон төрөл, зүйлийг хамгаалахад шинээр байгуулах тусгай хамгаалалттай газрууд чухал ач холбогдолтой юм. Монголд өргөн тархацтай цагаан зээр, монгол тарвага, хярс, мануулын дэлхийн тархацын ихэнх, тоо толгой, нөөцийн зонхилох хэсэг нь Зүүн бүсэд байдгийг анхаарч тархац нутгийн зарим хэсгийг тусгай хамгаалалттай газарт хамруулан хамгаалах үүднээс хэд хэдэн нөөц газар байгуулах, өмнө байгуулсан газруудыг өргөтгөх замаар зарим амьтдын тархац нутгийг хамруулах чиглэл баримтлах нь зүйтэй байна.
3. TXGN-ийн ангиллыг дахин хянан үзэж шаардлагатай ангиллыг бий болгох, ангилал дэвшүүлэх, хөдөлгөөнтэй болгох. Зүүн бүс нутагт нөөц газрууд маш олноор байгуулагдсан боловч хамгаалалтын менежмент хангалтгүй байгаагаас байгаль орчин дорийтох, биологийн төрөл зүйл хомсдох, нүүн дайжих байдал ажиглагдааар байна. Хамгаалалтад аваад олон жил өнгөрсөн боловч зорилго нь хангагдаагүй газруудын ангиллыг дээшлүүлэх асуудлыг судлан үзэх

нь чухал. Тухайлбал ойт хээр, хээрийн бусийн заагт орших эмзэг өвөрмөц ландшафттай, ойн хил урагш түрж байгаа хэсэгт орших Угтам уулыг 1993 онд байгалийн иж бүрдлийг хамгаалах нөөц газрын ангиллаар хамгаалалтад авсан байна. Угтамын байгалийн нөөц газар нь ой багатай Монгол орны нарс, хус, улиангар бүхий холимог ойн урд хил, дэлхийд ховордсон хялганат тал хээрийн экосистемийн хойт хил, ойн хил урагш түрж буй эмзэг экосистемийг хамгаалах зорилготой боловч өнөөг хүртэл нөхөн сэргээгүй улам доройтсоор байна. Зүүн бүсэд хийсэн биологийн төрөл зүйлийн цоорхойн үнэлгээгээр талбайн хэмжээг өргөтгөн хамгаалах шаардлагатай газарт олон газрууд сонгогдсон байна. Иймээс талбайн хэмжээг өргөтгөн ангиллыг дээшлүүлэн хамгаалах нь зүйтэй болов уу.

4. Экологийн коридор бий болгох. Зүүн бүс нутаг нь биологийн төрөл зүйл, түүний дотор цагаан зээрийн гол байршил нутаг учраас одоогийн байгуулагдсан ТХГН-ийн сүлжээг түшиглэн хооронд нь холбох замаар байгалийн коридор үүсгэн хамгаалах бүрэн боломжтой. Тухайлбал Хэрлэн гол, Онон гол, Улз голын хөндий бол хамгийн сайн коридор мөн.

 - Амьтдын нүүдлийн зам нь нэг ёсны коридор бөгөөд энэ нь ландшафтын тодорхой элементүүдтэй уялдсан байдаг. Ийм төрлийн коридорыг амьтны популяцитай холбож болно. Дорнод Монголын дархан цаазат газар-Тосон Хулстай-Яхь-Чулуунхороотын санал болгож буй хэсэгт сонгох боломжтой.
 - Коридор нь заавал урт үргэлжилсэн байх шаардлагагүй. Сүхбаатар аймгийн Мөнххаан, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумдын хилийн заагт орших Шилийн холбоо-Баянхаан-Бичигт-Батхаан-Тосон Хулстай-Гурваны шил-Яхь нуур гэх мэтээр олон коридорыг үүсгэж болно (2 дугаар зураг)



2 дугаар зураг. Зүүн бүсийн экологийн коридорын санал

5. Хөгжлийг байгаль орчинд нөлөөлөл багатай төлөвлөх. Монгол орны Зүүн бүс нутаг ашигт малтмалын асар их нөөцтэй, эдийн засгийн чухал орд газруудтай баян нутаг юм. Зүүн бүс нутгийн хэмжээнд 10 гаруй төрлийн ашигт малтмалын 300 гаруй орд, илрэлүүдийг судлан тогтоожээ. Эдгээр арвин баялаг нөөц, түүнийг ашиглахаар зэхж буй лиценз эзэмшигчдээс болж экологийн онцгой ач холбогдолтой газрууд хамгаалагдаж чадахгүйд хүрч байна. Тухайлбал Онон-Балжийн голын ай сав нь ашигт малтмалаар баян, тэр дундаа алтны нөөц ихтэй юм. Энд Онон мөрний хойд хэсэг дэх Агац,

Жаргалант, Хөмөл, Тэнүүн, Галттай, Онон зэрэг илрэлүүд дэх алт-кварцын, кварц, алт-сульфидийн бялхмалтай холбоотой эпитетмаль хүдрийн судлууд хамаарагдана. Анх Онон-Балжийн байгалийн цогцолборт газрыг байгуулахад хамгаалалтад авахаар төлөвлөсөн байсан газруудад нийтдээ 299108 га бүхий 13 газарт алтны лиценз олгосон учраас эдгээр газруудыг бүгдийг хилээс гаргаж улмаар цогцолборт газрыг А, Б 2 хэсэгт хувааж 415.7 мян.га талбай хамгаалалтад авсан юм. Үүнээс болж байгалийн муж, бус бүслүүр, экосистем, аялал жуулчлал хөгжүүлэх боломж зэргийг нь харгалзан тогтоосон газрууд хасагдаж, сав нутгийн экосистемийн төлөөлөл хангатгүй болж, дархан цаазтай цэн ба хар тогоруу, тоодог зэрэг олон төрөл зүйлийн тархац нутаг, Зүүн азийн олон зүйл усны амьтан хамгаалагдах боломжгүй болж байна. Аялал жуулчлал хөгжүүлэх гол газрууд Монгол орны хамгийн гүн Сөөгтийн агуй, байгаль түүхийн дурсгалт газрууд мөн хамгаалалтад орсонгүй.

Гэвч байгалийн асар их нөөц баялаг, ашигт малтмалыг ашиглахгүй байна гэдэг бас учир дутагдалтай тул Олон Улсын байгаль хамгаалах байгууллага (TNC)-аас дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн “Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх” арга нь байгаль орчны доройтлыг хязгаарлан зогсоох, баялаг нөөцөө зүй зохистой ашиглахад чухал ач холбогдолтой. Энэхүү аргазүйг хэрэгжүүлэх ажлууд хийгдэж байгаа бөгөөд юуны өмнө Зүүн бус нутгийн экологийн бус нутгийн үнэлгээг хийж хамгаалах шаардлагатай газрууд, ховор амьтан ургамлын тархац нутаг, хил хязгаар, хамгаалах шаардлагатай “халуун цэг”-ийг тогтоогоод байна. Судалгаанаас үзвэл Зүүн бус нутгийн 34% нь хүний үйл ажиллагаанд өртсөн буюу хүчтэй өөрчлөлтөд орсон байна. Мөн нийт нутгийн 19%-д ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байгаа нь тус бус нутагт байгаль хамгааллын асуудлыг уул уурхайн хөгжилтэй зохистой хослуулах, уул уурхайн нөлөөллийг бууруулах арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх бодит шаардлагыг бий болгож байна.

6. Хил дамнасан хамгаалалттай газруудыг байгуулах. Зүүн бус нутаг бол Монгол орны бусад нутгийн нэгэн адил гаднаас түрж орж ирсэн байгалийн томоохон мужуудын шилжилтийн зааг нутаг болдог болохоор экосистем, биологийн төрөл зүйлийн хувьд эмзэг орчин юм. Энд Сибирийн тайга, Дагдуурын хээр, Хянганы уулархаг их мужийн зүүн, баруун төгсгөлүүд түрж орсон болохоор биологийн төрөл зүйлийн хувьд баян байхын хамт эмзэг орчин болдог. Улсын хилээр хязгаарлагдахгүй биологийн төрөл зүйлүүд түрэн ирж, шилжин нүүдэллэж байдаг тул хил залгаа бусад газруудтай хамтран хамгаалах зайлшгүй шаардлагатай. Тус бус нутагт Монгол улсын хил дамнасан анхны дархан газар байгуулагдсан. Цаашид хэд хэдэн газруудыг шинээр байгуулах боломжтой, шаардлагатай байна (4 дүгээр хүснэгт).

4 дүгээр хүснэгт

	Шинээр байгуулах хил дамнасан ТХГН-ийн нэр	Хамтарсан дархан газар байгуулах газар
1	Хэнтийн	Хан Хэнтийн ДЦГ (Монгол Улс) Чикой-Минжийн ДЦГ (ОХУ)* (байгуулагдаагүй, төсөл явж байгаа)
2	Онон-Сохондын	Онон-Балжийн БЦГ (Монгол Улс) Сохондын шим мандлын ДЦГ (ОХУ)

3	Дагуурын	Монгол Дагуурын ДЦГ (Монгол Улс)
		Дагуурын ДЦГ (ОХУ)
		Далайнуурын ДЦГ (БНХАУ)
4	Нөмрөгийн	Нөмрөгийн ДЦГ (Монгол Улс)
5	Дорнод Тал Хээрийн	Дорнод Монголын ДЦГ (Монгол Улс) Bai Yin Ao Bao БНГ Nature Reserve (БНХАУ)

7. Аялал жуулчлал хөгжүүлэх. Зүүн бүс нутгийг хамгаалах, зохистой ашиглахад аялал жуулчлал чухал үүрэгтэй. Тус бүс нутаг нь дэлхийд ховор хялганат хээрийн нэрийн хуудас болохоос гадна түүх соёлын дурсгал арвантай, аялал жуулчлалын нөөц даац ихтэй, үнэ цэнэтэй нутаг юм. Иймээс эдийн засаг, нийгэм, экологийн бодит боломжинд тулгуурласан гадаад, дотоодын болон хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломжтой. Үүний тулд байгаль орчны өөрчлөлт, доройтол, зах зээлийн өрсөлдөөний дарамт, аялал жуулчлал хосолсон схемийг оновчтой зохицуулах бодлого баримтлан, эрхзүйн орчныг боловсронгуй болгох нь зүйтэй юм.

Дүгнэлт

1. Монгол орны зүүн бүсэд нутагт бүслэг зүй тогтолт ландшафтуудаас хуурай хээр, жинхэнэ хээр эзлэх бөгөөд дараа нь ойт хээр, нугат хээр, цөлжүү хээрийн ландшафтууд багтана. Бүслэг бус ландшафтуудаас элсэн хуримтлал, хужир мараа, татмын нуга тархсан. Хээрийн ландшафт гол төлөөлөл болно.
2. Ландшафтын ашиглалт хамгаалалтын хамгийн сонгомол хэлбэр бол газар нутгийг дархлан хамгаалах юм. Зүүн бүсийн нийт нутгийн 17.5 хувийг буюу 5028.3 мянган га талбайг улсын хамгаалалтад авсан нь Монгол Улсын төр засгаас байгаль хамгаалах талаар хэрэгжүүлж буй бодлогын шинжтэй томоохон бодит үйл ажиллагаа юм.
3. Зүүн бүсийн газар нутгийн хялганат хээрийн экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглахад хамгаалалтын оновчтой менежментийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ашигласан хэвлэл

1. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, 1998
2. Доржготов Д., Оюунгэрэл Б. “Монгол дахь Амар мөрний ай савын экологи-газарзүйн байдал, хил дамнасан ТХГН байгуулах асуудалд” илтгэл. “Природоохранное сотрудничество Читинской области и автономного района внутренняя Монголия в трансграничных экологических регионах”. Олон Улсын хурал, ОХУ, Чита, 2007 он.
3. Оюунгэрэл Б. Хан Хэntийн тусгай хамгаалалттай газар нутаг. УБ., 2004
4. Оюунгэрэл Б. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг. УБ., 2004
5. Оюунгэрэл Б. Онон-Балжийн БЦГ, Хан Хэntийн ТХГН-ийн хооронд экологийн коридор тогтоох үндэслэл. Тайлан. 2008
6. Оюунгэрэл Б. Монгол орны зүүн бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, өнөөгийн байдал, хэтийн төлөв (тайлан). TNC-төсөлд. 2009 он.